



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/298

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хархорин суманд Коронавируст (COVID-19) цар тахлын голомт бий болсонтой холбоотойгоор тусгаарлах байрны зардалд 15,000,000 (арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

111 062J